



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 709

Улаанбаатар хот

「Үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой, 4 нэрийн, нийт 6,161,500.00 (зургаан сая нэг зуун жаран нэгэн мянга таван зуу) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 6,161,500.00 (зургаан сая нэг зуун жаран нэгэн мянга таван зуу) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн захирал Б.Баяржавхлан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийн ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

137100917
30-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 1 дугаар сарын 13-ны өдрийн
709 дугаар тогтоолын хавсралт

ШУТИС-ийн харьяа өмнөговь аймаг дахь технологийн дээд сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,
үлдэгдэл өртөггүй, ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоох хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр, төрөл	Ашиглалтанд орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэм жээ	Нийт балансын үнэ /хуримтлагдсан элэгдэл/ (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)			Цаашид ашиглах хугацаа /жилээр/
						Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэм жээ	Нийт үнэ (төгрөг)	
1	Сандаг	8/31/2016	56,250.00	4	225,000.00	56,250.00	4	225,000.00	1
2	Төмөр хөлтэй сандал	7/31/2015	150,000.00	10	1,500,000.00	150,000.00	10	1,500,000.00	1
3	Сандаг	6/30/2016	50,000.00	20	1,000,000.00	50,000.00	20	1,000,000.00	1
4	Ширээ уншлагын	12/31/2009	43,500.00	79	3,436,500.00	43,500.00	79	3,436,500.00	1
	НИЙТ ДҮН			113	6,161,500.00 (зургаан сая нэг зуун жаран нэгэн мянга таван зуу)		113	6,161,500.00 (зургаан сая нэг зуун жаран нэгэн мянга таван зуу)	